

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**
25/01

Огноо:	2025 оны 01 сарын 28
Цаг:	10:00
Хурал хуралдуулах газар /хаяг, байршил/:	Компанийн байр (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхарт)
Хурлын дарга:	Ч.Ганхуяг
Хуралд оролцсон:	Хувьцаа эзэмшигчид, Хурлын дарга, Хурал зохион байгуулах комисс, Тооллогын комиссын бүрэлдэхүүн
Хурлын ирц:	50.16 хувь
Хурлаар хэлэлцэх асуудал:	- Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай; - Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай; - Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай; - Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай; - Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орсон төслийг батлах.

“Өндөрхаан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг энэхүү хурлын дэгийн дагуу 10:00 цагт нээв.

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

Ч.Ганхуяг: Өглөөний мэнд, Өнөөдрийн хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 24/15 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар Ч.Ганхуяг би даргална. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. (хурлын дэгийг танилцуулав.) За ингээд хурлын дэгийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын ирцийн талаар мэдээллийг тооллогын комиссын бүрэлдэхүүн нийт хувьцаа эзэмшигчдэд мэдээлж өгнө үү.

Тооллогын комисс: Өнөөдрийн “Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 111,879 ширхэг хувьцаанаас 56,114 ширхэг буюу 50.16 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- Хэлэлцэх асуудал №1,2 Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай, Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай.

Ч.Ганхуяг: Хувьцаа эзэмшигчдэдээ дараах байдлаар танилцуулав.

1. Өндөрхаан ХК-ийн зарласан хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 2,127,676 ширхэг болгох;

2. Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 12,407 төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Авлагын гэрээний холбогдох заалтын дагуу 25,009,993,379 төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэхээр энэхүү хуралд нийт хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулж байна.

Холбогдох танилцуулгыг нийт хувьцаа эзэмшигчдэд өрийг хувьцаагаар солих төслийн хамт танилцуулан хэлэлцэв.

Та бүхэн цахим хэлбэрээр болон Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн байранд ирж хурлын материалтай танилцсан байх гэж найдаж байна. Мөн хурлын материалтай дахин танилцахыг хүсвэл хурал зохион байгуулж буй комиссоос авах боломжтой.

- Хэлэлцэх асуудал №3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай.

Ч.Ганхуяг: Өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах гэж буйтай холбогдуулан Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд 25,009,993,379 үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах тухай асуудлыг энэхүү хурлын хэлэлцэх асуудалд оруулан эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

Холбогдох нөхцөлийг нийт хувьцаа эзэмшигчдэд танилцуулан хэлэлцэв.

- Хэлэлцэх асуудал №4 Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай.

Ц.Тайшир: Та бүхэнд өмнө нь буюу хэлэлцэх асуудал 1 болон 2-ыг танилцуулсантай холбоотойгоор Компаниас нэмж гаргах 2,015,797 ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг үндэслэн өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байхаар шийдвэрлүүлэхээр танилцуулж байна.

Холбогдох нөхцөлийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

- Хэлэлцэх асуудал №5 Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай

Ч.Ганхуяг: Компанийн Дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж, өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлуулахаар танилцуулж байна.

Дүрмийн 4.1 дэх хэсэгт “ Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 111,879 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.” гэж заасныг “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,127,676 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.” гэж өөрчлөх.

Дүрмийн 4.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуун) төгрөг байх бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо 111,879 ширхэг байна.” гэж заасныг “Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн гаргасан хувьцааны нэрлэсэн үнэ 100 (нэг зуун) төгрөг байх бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо 2,127,676 ширхэг байна.” гэж тус тус өөрчлөхөөр танилцуулж хэлэлцэв.

АСУУЛТ, ХАРИУЛТ:

Байхгүй.

САНАЛ ХУРААЛТ:

Тооллогын комисс:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 56,114 ширхэг буюу 50.16 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %
Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%
Түдгэлзсэн: 56,114 Ширхэг буюу 100%
Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%
 - 1.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:
Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.
 - 1.3. Хүчингүй санал.
Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.
2. Хурлаар хэлэлцсэн Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 56,114 ширхэг буюу 50.16 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 2.1. Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %
Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%
Түдгэлзсэн: 56,114 Ширхэг буюу 100%
Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%
 - 2.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:
Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.
 - 2.3. Хүчингүй санал.
Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.
3. Хурлаар хэлэлцсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 56,114 ширхэг буюу 50.16 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 3.1. Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%

Түдгэлзсэн: 56,114 Ширхэг буюу 100%

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

3.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

3.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

4. Хурлаар хэлэлцсэн Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 56,114 ширхэг буюу 50.16 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

4.1. Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%

Түдгэлзсэн: 56,114 Ширхэг буюу 100%

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

4.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

4.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

5. Хурлаар хэлэлцсэн Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон төслийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 56,114 ширхэг буюу 50.16 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

5.1.Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%

Түдгэлзсэн: 56,114 Ширхэг буюу 100%

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

5.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

5.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 2,127,676 (Хоёр сая нэг зуун хорин долоон мянга зургаан зуун далан зургаа) ширхэг болгох тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.

2. Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 12,407 (*Арван хоёр мянга дөрвөн зуун долоон тогрог*) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 2,015,797 (*Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо*) ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Авлагын гэрээний холбогдох заалтын дагуу 25,009,993,379 (*хорин таван тэрбум есөн сая ерэн гурван мянга гурван зуун далан ес*) төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэх тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
3. Өндөрхаан ХК-ийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах гэж буйтай холбогдуулан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлийн дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулах тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
4. Компаниас нэмж гаргах 2,015,797 (*Хоёр сая арван таван мянга долоон зуун ерэн долоо*) ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлүүлэхгүй байх тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.
5. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах тухай асуудлыг түдгэлзүүлсүгэй.

ХУРЛЫН ХААЛТ:

Ч.Ганхуяг: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан

Хурлын дарга Ч.Ганхуяг

Тэмдэглэл хөтөлсөн

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ижилцэцэг:

